



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага





## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



**Хэрэгжих хугацаа:** 2021-2024



**Санхүүжүүлэгч:** Европын холбоо



**Хэрэгжүүлэгч:** НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага



**Хамтрагч:**

Улсын Их Хурал, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний аудитын газар, Мэргэжлийн хяналтын газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, бусад



**Ашиг тус хүртэгч:**

Ажил хайгч, ажилгүй эсвэл бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, түүний дотор алслагдсан орон нутгийн залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах хүсэлтэй ажилчид, ажил олгогчид



**Төслийн зорилго:**

- Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Хөдөлмөр эрхлэлтийн салбарт төрийн үйлчилгээг үр дүнтэй, хариуцлагатай, шуурхай хүргэхэд туслалцаа үзүүлэх
- Төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн институтын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх



## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ  
ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ  
ЧАДВАР, БОЛОМЖИЙГ  
НЭМЭГДҮҮЛЭХ

БОДЛОГО, ТӨСВИЙН  
УЯЛДААГ ХАНГАХ



3



ТӨСВИЙН ХЯНАЛТ,  
ИЛ ТОД БАЙДАЛ



4  
ХӨДӨЛМӨРИЙН  
ИНСТИТУТЫГ БЭХЖҮҮЛЭХ  
ЗАМААР ОЛОН УЛСЫН  
ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ  
ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ



## БҮРЭЛДЭХҮҮН 1: БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ



### 1.1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ҮР ДҮНГИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ (ДХЗХ)

- Үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлтийг шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулна.
- Үр дүнгийн мэдээлэлд үндэслэж ДХЗХ-г бэхжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.



### 1.2. ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

- Төсвийн багц хөтөлбөрүүд бодлого, үр дүнтэй уялдсан байна.
- Үр дүнд суурилсан төсвийн хяналт-шинжилгээ, тайлагналтад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ), бодлогыг төсөвт хэрхэн тусгасан талаар Иргэдийн төсөвт оруулна.



### 1.3. НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ

- Салбарын төсвийн зарлага, институцийн бүтцэд үнэлгээ хийж, төсвийн шийдвэр гаргахад ашиглана.
- Салбарын хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэл тодорхойлогдсон байна.
- Бодлого хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог сайжруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.



### 1.4. ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО (ТХЗ)-Д ЧИГЛЭСЭН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР САНГИЙН ЯАМ, САЛБАРЫН ЯАМДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

- Бүсийн сургалт зохион байгуулж, олон улсын туршлага судална.
- Ажлын байран дахь чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.





## БҮРЭЛДЭХҮҮН 2: ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ



### 2.1. ТӨСВИЙН ХЯНАЛТАНД УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

- Үр дүнд суурилсан бодлогын шинжилгээ, хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Үр дүнд суурилсан төсвийн хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Бодлого, төсвийн уялдааг хангахад УИХ-ын зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг сайжруулна.



### 2.2. ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

- Салбарын бодлогын шинжилгээ хийнэ.
- Төсөвт хяналт-шинжилгээ хийх Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ын чадавхыг сайжруулна.
- Төсөвт хяналт-шинжилгээ хийх, хянах чиглэлээр ИНБ, Хэвлэл мэдээллийн чадавхыг сайжруулна.



### 2.3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫГ БЭХЖҮҮЛЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАНА

- ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийнэ.
- Аудитын Иргэдийн оролцооны стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Гүйцэтгэлийн аудитын чадавхыг сайжруулна.





## БҮРЭЛДЭХҮҮН 3: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДВАР, БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



### 3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ САЙЖРУУЛЖ, ХАРИЛЦАН УЯЛДААГ ХАНГАНА

- Хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн зураглал гарган үнэлгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлно.
- Эдийн засгийн нөхцөл байдал, хөдөлмөрийн зах зээл, орон нутгийн бодлоготой уялдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээ бий болгоно.
- Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл солилцоог сайжруулна.



### 3.2. ИННОВАЦИ, ГАРААНЫ БИЗНЕС, ТЕХНОЛОГИ, БИЗНЕС ИНКУБАТОР, БИЗНЕС САНААГАА ҮЙЛ ХЭРЭГ БОЛГОХ ЭКОСИСТЕМ ХӨГЖҮҮЛНЭ

- Инноваци, гарааны бизнесийн санаачилгыг хэрэгцээнд тулгуурлан дэмжих, мэдлэг хуваалцах зорилго бүхий цахим платформ бий болгоно.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хандивлагч, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн сайн туршлагыг үндэсний бодлогод тусгана.
- Залуучууд, алслагдсан нутгийн ажил хайгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гарааны бизнесийг дэмжинэ.



### 3.3. ЦАЛИН ХӨЛСТЭЙ БОЛОН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДАВХ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ

- Загварчлах сэтгэлгээ болон хувь хүний хэрэгцээ шаардлага, зан төлөвт нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсролын байгууллагын тогтолцоонд нэвтрүүлж хөгжүүлнэ.
- Зайнаас хөдөлмөр эрхлэх, ажил мэргэжлийн зөвлөгөө авах, ур чадварын сургалтад хамрагдах цахим платформыг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зайнаас хүргэх чадавхыг дээшлүүлэх замаар хүртээмж, хамрах хүрээг сайжруулна.
- Ажил олгогчийг дэмжсэн, ажил олгогч-ажилтны харилцааг хөгжүүлсэн, ажлын байран дээр дадлагажих хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.



### 3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХЭД ҮР ДҮНТЭЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ НОТӨЛГӨӨ, СУРГАМЖ ЦУГЛУУЛАХ, УЛМААР БОДЛОГОД ТУСГАХ ЗОРИЛГООР ТУРШИЛТЫН ТӨСЛҮҮД ХЭРЭГЖҮҮЛНЭ

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах, залуучуудыг хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээнд олноор ажиллуулах боломж бүхий төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны загварыг боловсруулж, туршина.
- Монгол Улсын агро-бизнес эрхлэгчдэд хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг боловсронгуй болгох бүтэц, зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг хийж, туршихад дэмжлэг үзүүлнэ.
- Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ.
- Монгол Улсын агро-бизнес суурилсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тулгамдаж буй сорилт бэрхшээлийг тодорхойлон, загвар боловсруулж туршина.
- Арьс шир, үслэг ба ноосон бүтээгдэхүүн зэрэг хүнсний бус хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих загвар сургалтын төв байгуулж, туршина.



## БҮРЭЛДЭХҮҮН 4: ХӨДӨЛМӨРИЙН ИНСТИТУТЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ



### 4.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭТЭЙ НИЙЦҮҮЛНЭ.

- Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 1947 оны 81 дүгээр конвенц болон Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 1969 оны 129 дүгээр конвенцод нэгдэн орох, ОУХБ-ын суурь болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенцуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Хөдөлмөрийн хяналт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах, түүний дотор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд зөвлөгөө өгнө.
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт салбар хорооноос олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, тэдгээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хянан үзэх, хэлэлцэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтууд, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг судалж, хэрэгжилтийн түвшинд буй хийдэл, дутагдал, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцүүлэх шаардлага, хөдөлмөр эрхлэлтийг албажуулах чиглэлүүдийг тодорхойлно.
- Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийг хэрэгжүүлэх, зохистой хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг албажуулах, хамтын хэлэлцээг үр дүнтэй дэмжих хүрээнд МАОЭНХ, МҮЭХ-нд дэмжлэг үзүүлнэ.
- Мэргэжлийн бүлгүүд, Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээнээс залуучуудын хөдөлмөрлөх эрхийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нь албан болгоход чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.



### 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛНА.

- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Хяналт шалгалтын арга хэмжээг баримт нотолгоонд суурилан боловсруулахын тулд мэдээлэл (нас, хүйсийн задаргаатай), цуглуулах, дүн шинжилгээ хийх болон тархаах өнөөгийн байдалд үнэлгээ хийнэ.
- МХЕГ-ын хяналт шалгалтын мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээллийн өнөөгийн системийг сайжруулах асуудлаар зөвлөмж боловсруулна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар бүх түвшний нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуйн болон хөдөлмөрийн хяналтын байцаагч нар, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийн ажилтнуудыг сургана.





НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр  
НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний  
гудамж-14, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-14201, Монгол Улс



976-11-327585



976-11-326221



registry.mn@undp.org



www.mn.undp.org



НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн  
байгууллага  
НҮБ-ын байр, Нэгдсэн Үндэстний  
гудамж-14, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-14201, Монгол Улс



976-11-310248



fao-mn@fao.org



www.fao.org/mongolia



Олон улсын хөдөлмөрийн байгууллага  
НҮБ-ын байр, 604 тоот  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14201, Монгол Улс



976-70110640 (4402)



976-11-320624 (4402)



<https://www.ilo.org/>